



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 09/04

Хөхбүрд

Хамтарсан баг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын ээлжит есдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Орон нутгийн хэмжээнд гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, арга хэмжээ зохион байгуулах гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийг олон нийтэд сурталчлах хамтарсан багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Багийн ахлагч – Засаг дарга

Гишүүдэд Боловсролын нийгмийн ажилтан

Эрүүл мэндийн нийгмийн ажилтан

Халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Цэцэрлэгийн эрхлэгч

Насан туршийн боловсролын менежер

Сумын Цагдаагийн хэсгийн төлөөлөгч

Сумын цагдаа


4 багийн Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга-Нийгмийн бодлогын мэргэжилтэн

2. Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг сумын Засаг даргад, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажил, арга хэмжээний санхүүгийн эх үүсвэрийг төлөвлөн төсөвт тусгуулах ажлын тайланг жил бүр хуралдаанд танилцуулж үнэлэлт дүгнэлт гаргуулан ажиллахыг нарийн бичгийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Нийгэм цахим бодлогын хөгжлийн хороонд даалгасугай.

ДАРГА  Б.ОТГОНБАЯР



648801029